**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2018 оны 08 сарын 06 өдөр Дугаар А/38 Улаанбаатар хот

Нийгмийн хамгааллыг дэмжих сарыг
зохион байгуулах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/264, А/295 дугаар тушаал, төвийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.3.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн хэмжээнд жил бүрийн 8 дугаар сарыг "Ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар" болгон, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тайланг 9 дүгээр сарын 10-ны дотор төвийн Удирдлагын зөвлөлд танилцуулан, 9 дүгээр сарын 15-ны дотор ЭМЯ-нд хүргүүлэхийг Эрдэм шинжилгээ, хүний нөөц, хамтын ажиллагааны албаны дарга Н.Янжиндуламд үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг хууль, журмын дагуу зарцуулахыг Ахлах нягтлан бодогч С.Алтаннамарт зөвшөөрсүгэй.

4. Уг тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор Д.Амарт даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Н.ЭРДЭНЭБАЯР

1118266548 ☎9128905

ЦССУТ-ийн захирлын 2018 оны 08 сарын 06 өдрийн А/ 37 дугаар тушаалын хавсралт

1118266548 9128905

## ЦССУТ-ИЙН “АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ ДЭМЖИХ САР”- ЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.07.30

| № | Үйл ажиллагааны нэр | Хариуцах эзэн | Шалгуур үзүүлэлт | Хугацаа | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төвийн нийт ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулах | СТСБА ЭШХНХАА | Хамрагдсан тоо, хувь | Сардаа | Ажилтны эрүүл мэндийн талаарх мэдээллийн сан үүснэ. Эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөлт оновчтой болно. |
| 2 | Төвийн ерөнхий захирал ажилтан бүрийг хүлээн авч уулзах ажлыг зохион байгуулах | Хүний нөөцийн ажилтан Б.Амаржаргал | Уулзалтын тэмдэглэл, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн байдал | Сардаа | Ажилтны сэтгэл ханамж сайжирна. |
| 3 | Төвийн шаардлагатай ажлын байрыг эрсдлийн үнэлгээнд хамруулах | Халдвар судлаач эмч Э.Тунгалагтуяа | Эрсдлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн ажил | Сардаа | Ажилтан ажлын байранд эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ. |
| 4 | Шинээр ажилд орсон болон өмнө жил элэгний В,С вирусын халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаагүй эрүүл мэндийн ажилтнуудыг шинжилгээнд хамруулах | Халдвар судлаач эмч Э.Тунгалагтуяа | Элэгний В, С вирусын халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдсан ажилтны тоо, хувь | Сардаа | Ажилтан халдвараас сэргийлэх мэдлэг, хандлага, дадалтай болно. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Элэгний В вирусын эсрэг дархлаажуулалтад үнэ төлбөргүй хамруулах Төвийн ажилтнуудын судалгааг гаргаж, хамруулах | Халдвар судлаач эмч Э.Тунгалагтуяа | Дархлаажуулалтанд хамрагдсан ажилтны тоо, хувь | Сардаа | Ажилтныг ажлын байрны эрсдлийн улмаас элэгний В вирусын халдвар авахаас сэргийлнэ. |
| 6 | Элэгний С вирусын халдвар илэрсэн ажилтныг үнэ төлбөргүй эмчилгээнд хамруулах судалгааг гаргаж, хамруулах | Хүний нөөцийн ажилтан Б.Амаржаргал, Халдвар судлаач эмч Э.Тунгалагтуяа | Эмчилгээнд хамрагдсан ажилтны тоо, хувь | Сардаа | Ажилтны элэгний өвчлөл буурч, хөдөлмөрийн чадвар сайжирна. |
| 7 | Ажилтны аав, ээж, ах, дүү, нөхөр, хүүхдэд өөрийн байгууллагын түвшинд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлттэй үзүүлэх боломжийг судлан, Төвийн дотоод журамд тусгах | Нэгдсэн лаборатори ЭШХНХАА | Хөнгөлттэй үйлчлүүлсэн ажилтны төрсөн аав, ээж, ах, дүү, нөхөр, хүүхдийн тоо, хувь | Сардаа | ЭМСайдын 2010 оны 224 дүгээр тушаалын хэрэгжилт хангагдана. |
| 8 | Эрүүл мэндийн салбарын оны шилдэгийн шагналд Төвийн ажилтанг нэр дэвшүүлэх | ЭШХНХАА | Нэр дэвшүүлсэн тухай баримтжуулалт | 8 сарын эхний 10 хоногт | Ажилтнуудыг идэвхижүүлэн, сэтгэл ханамжийг сайжируулна. |
| 9 | Эрүүл мэндийн байгууллагын хөдөлмөрийн яармагт оролцох | ЭШХНХАА, СТСБА | Шинээр ажилд орсон ажилтны тоо | 8 сарын 09-20 | Сул ажлын байранд ажилтан сонгон шалгаруулж авах боломж бүрдэнэ. |
| 10 | ХЭМАБ-ын зөвлөлийн гишүүдээс Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар сургалтанд хамруулж, нийт ажилтнуудад мэдээлэл хийх | ХЭМАБ-ын зөвлөл | Сургалтанд оролцсон тухай баримтжуулалт ба нийт ажилтнуудад мэдээлэл хийсэн тухай бүртгэл | 8 сарын 25-31 | Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөлт сайжирна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | Төвийн үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг эрчимжүүлэх | ЭШХНХАА Хэвлэл мэдээллийн ажилтан Д.Лхагвадорж | Сурталчилгааны ажлын тоо, баримтжуулалт | Сардаа | Төвийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, хандлага сайжирна. |
| 12 | Төвийн хүний нөөцийн судалгааг шинэчлэх | ЭШХНХАА Хүний нөөцийн ажилтан Б.Амаржаргал | Судалгааны цахим сантай болсон байна. | Сардаа | Хүний нөөцийн төлөвлөлт сайжирна. |
| 13 | Ажилтны эрүүл мэндийг дэмжих “Хөдөлгөөн эрүүл мэнд” клубын үйл ажиллагааг идэвхижүүлэх | Сэтгэлд нийцсэн үйлчилгээний баг, Хүний нөөцийн ажилтан | Клубын гишүүдийн тоо нэмэгдэж, үйл ажиллагааны төрөл нэмэгдсэн байна. | Сардаа | Ажилтны сэтгэл ханамж сайжирна. |